

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

ИЛТГЭХ ХУУДАС

№ 02 (2024)

Музейн үзүүлэгийн танхимын үзмэрийн хадгалалт хамгаалалтын байдалд үзлэг, хяналт хийсэн тухай

2024 оны 07 дугаар сарын 09

Улаанбаатар хот

2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн музейн захирлын баталсан “Музейн үзүүлэгийн танхимын үзмэрийн хадгалалт хамгаалалтын байдал, захирлын дэргэдэх арга зүйн зөвлөлийн 2024 оны 5 дугаар сар 29-ний өдрийн үзлэгийн мөрөөр авсан арга хэмжээ”-г шалгах удирдамжийн дагуу 2024 оны 7 дугаар сарын 5-ны өдөр дотоод хяналт шалгалтын ажилтан, арга зүйч Б.Өлзийбаяр, менежер Б.Нарангэрэл, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал, Эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн нарын бүрэлдэхүүнтэй хяналт, шалгалт хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” 311 дүгээр тогтоол, Гар урлал болон урлагийн зориулалттай зүйлс. Музейн үйл ажиллагаанд тавигдах шаардлага MNS5634:2006 стандарт (цаашид музейн стандарт гэх), Улаанбаатар хотын музейн захирлын 2024 оны “Журам батлах тухай” А/11 дүгээр тушаал, 2024 оны музейн дотоод хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөө, захирлын дэргэдэх арга зүйн зөвлөлийн 2024 оны 2 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн удирдамжид заасан музейн стандартын 14 заалт, арга зүйн зөвлөлийн үзлэгийн мөрөөр авч хэрэгжүүлэх 7 арга хэмжээний биелэлтийг комиссын гишүүд нэг бүрчлэн шалгаж үзлэг шалгалтыг хийж дүгнэлээ.

Үзлэгийг комиссын гишүүд биечлэн үзэж танилцах, асуулт асуух, удирдамжид заасан хяналтын хэвлэмэл хүснэгтэд 0-5 оноогоор үнэлгээ хийж, гар тэмдэглэл хөтөлж ажиллав.

Дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан, менежер, бүртгэл мэдээллийн санч, эрдэм шинжилгээний ажилтан нарын музейн үзүүлэгийн танхимын үзмэрийн хадгалалт хамгаалалтын байдал, захирлын дэргэдэх арга зүйн зөвлөлийн үзлэгийн мөрөөр авсан арга хэмжээнд өгсөн оноог харьцуулахад **4.08 оноо буюу “хангалттай”** үнэлгээ авлаа.





Музейн үзүүлэгийн танхимын үзмэрийн хадгалалт хамгаалалтын байдалд үзлэг хийсэн тухай хүснэгт

Д/д	Музейн стандартын заалтууд	Тайлбар
1.	12.9.4 Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөөний ба үзмэрийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журмыг музейн захирал батална. (Хуваарийн дагуу арчилгаа, цэвэрлэгээ хийж байгаа эсэх)	Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөөний ба үзмэрийн арчилгаа, сэлбэлт, цэвэрлэгээний дэг журмыг Музейн захирлын 2022 оны А/54 тоот тушаалаар батлуулсан “Цэвэрлэгээний хяналт шалгалтын хүснэгт”-ийг хавсралтаар батлуулан холбогдох албан хаагчдад танилцуулж, хяналт тавьж ажиллаж хэвшсэн. Хуваарийн дагуу арчилгаа, цэвэрлэгээ хийж хэвшсэн байна. Арга зүйч шинээр үзмэр харгалзагчаар ажилд орсон Б.Ариунцэцэгт ажлын байрны мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, үзмэрийн арчилгаа цэвэрлэгээний журам танилцуулсан.
2.	12.9.5 Үзмэр байгаа газарт жилд 2 удаа ариутгал хийнэ. Шаардлагатай бол нэмэгдэл ариутгал устгал хийнэ. Ариутгалыг	“Хан судар” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу 2024 оны 5 дугаар сарын 9нд музейн үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөөний нийт 250 мкв талбайд шавьж устгал - жильюгийн 1,5% уусмалаар, мэрэгч устгал - бромадиолоны өгөөш 5% уусмалаар, халдваргүйжүүлэлт хлорсепт 17-ийн 0,3% уусмалаар

	<p>мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.</p>	<p>хийж гүйцэтгүүлсэн. Музейн хашаа, ажилтнуудын өрөөнд хулгана үзэгдсэн тул хулганы наадаг хор, хавх худалдан авч байрлуулсан ба сан хөмрөгийн өрөөнд наадаг хоронд батгана, ялаа наалдсан, ажилтнуудын өрөөнд хоронд хулгана наалдаж байсан. Тиймээс музейн арга зүйч бусад музей болон шавж устгалын байгууллагын судалгаа хийн Orkin Mongolia гэх байгууллагаас мэргэжилтэн урьж үзлэг хийлгэсэн. Тухайн байгууллагаас 4.5 сая төгрөгийн үнийн санал илгээсэн. Гэвч музейн төсөвт тухайн зардал байхгүй.</p>
<p>3.</p>	<p>12.9.6 Үзмэр, сан хөмрөг байгаа өрөө, танхимууд нь дулаан ба чийгшилт, гэрэлтүүлэг хэмжилтийн хэрэгсэл ба чийгшүүлэх, агааржуулах, төхөөрөмжөөр тоноглогдсон байна.</p>	<p>2023 онд зориулалтын баталгаат газраас чийгшил, дулаан, гэрэл, дуу чимээ хэмждэг олон үйлдэлт төхөөрөмж авч тогтмол хэмжилт хийж байна.</p>
<p>4.</p>	<p>12.9.7. Үзүүлэгийн танхим, сан хөмрөгийн өрөө бүрийн дулаан ба чийгшилтийн хэмжилтийг сар бүр, үзүүлэгийн танхимын гэрэлтүүлгийн хэмжилтийг жилд 2-4 удаа шалгаж тэмдэглэл хөтөлнө. Хэмжигч хэрэгслийн заалтын тэмдэглэлийг үндэслэн хадгалалтын тохирсон орчныг бүрдүүлэх арга хэмжээ авна.</p>	<p>Үзүүлэгийн танхимын чийг дулааныг сард 20 удаа, гэрэлтүүлгийг сард 1 удаа тогтмол хэмжилт хийж тэмдэглэл хөтөлдөг. Танхимын чийгшлийн дундаж түвшин 35-40%, дулаан 18-22 ° С. Чийгшилт нэмэгдүүлэхийн тулд саванд ус хийж тавих, автомат чийгшүүлэгч ашигладаг.</p>
<p>5.</p>	<p>12.9.8. Гэрэлтүүлэг үзмэрийн байршилд зохицон зөөвөрлөх, хөдөлгөх боломжтой байна.</p>	<p>Үзүүлэгийн 3 дугаар танхимд суурилуулсан гэрэлтүүлэг нь 2011 онд шинээр тавьсан ба 60 хувь нь ажиллагаагүй болсон. Уг танхимын гэрэлтүүлэгийг шинэчлэх шаардлагатай.</p>




			
6.	14.7 Үзүүлэгийн орчин ба тоног төхөөрөмж нь үзмэр хадгалах шаардлагыг хангасан байна.	2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хөрөнгөөс (100 сая төгрөг) санхүүжихээр НЗД-ын 2023 оны А/1011 захирамж гарсан. Уг захирамжийн хүрээнд НХААГ/202309350 дугаартай “Улаанбаатар хотын музейн барилгын засвар болон бие засах газрын нөхцөлийг сайжруулах ажил” тендерийг 2023 оны 11-12 дугаар сард НЗА-ын албанаас 3 удаа зарласан ч гүйцэтгэгч байгууллага сонгон шалгаруулалтад тэнцээгүйн улмаас санхүүжилт буцаан татагдсан. Музейн барилгын гадна фасад, дээвэрт сэргээн засварлалт хийх, үзүүлэгийн танхим болон ариун цэврийн өрөөнд их засвар хийх ажилд төсөв тодотголоор 100 сая төгрөгний санхүүжилтийг дахин батлуулах зорилгоор НЗДТГазар, НИТХ-ын төлөөлөгчдөд 2024 оны 31,32,42, дугаар албан бичгээр хүргүүлсэн болно. Үзүүлэгийн 3 дугаар танхимд бш хөшиг шинээр хийлгэсэн.	
7.	16.4 Музей дотор үүдэнд ерөнхий танилцуулга, үзүүлэгийн тойм зураг, сэтгэгдлийн дэвтэр, тасалбар түгээх, тээш хадгалах байр, өлгүүр, сандал, хогийн сав байна.	Музейн үүдэнд мэдээллийн самбарт музейн товч танилцуулга, үүдний хэсэгт хүлээлгийн сандал, хогийн сав байна. Үзэгчдэд тасалбар түгээх тусгай өрөө байхгүй тул музейн үзмэр хянагч тасалбар түгээдэг. Музейн үзэгчийн цүнх, хувцас зэргийг түр хадгалах зориулалтын шүүгээ байхгүй.	
8.	17.1 Музейн барилга, цахилгаан сүлжээний бүрэн бүтэн байдалд 2 жил тутамд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулна.	Мэргэжлийн Хяналтын газрын 2019.08.05-ны өдрийн 02-07-395/1185 тоот, 2013.08.20-ны өдрийн 02-02-89/1302 тоот улсын байцаагчийн “Барилгын ашиглалтын төлөв байдлын тухай” дүгнэлтэд Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм “Барилгын норм ба дүрэм 13-04-03”-ийн 2 дугаар хүснэгтэд зааснаар үндсэн хийц бүтээцийн ашиглалтын хугацаа дууссан, Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” БНБД 22.0101*/2006-ийн шаардлага, хангахгүй байна. МХГ-ын 2022.02.21-ний өдрийн 02-02/577 тоот албан бичигт ЗГ-ын 2017 оны 353 дугаар дугаар тогтоолын 3.3, 37 дахь заалтын дагуу техник зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэсэн зөвлөмж хүргүүлсэн байна. Музей нь одоог хүртэл галын дүгнэлтгүй байгаа нь “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийн зөрчиж байна. НОБГ-т хүсэлт гарган галын дүгнэлт гаргуулах шаардлагатай.	
9.	17.2 Галын хор байрлуулж зааврын дагуу ашиглана.	Үзүүлэгийн танхим 10 ширхэг галын хортой. Бүгд ногоон буюу хэвийн заалттай байна.	

		<p>Гал унтраагуурыг сар бүр лацыг шалган хорны нунтагыг дагтаршихаас сэргийлж хорыг сэгсэрч, хорон дээрх хяналтын хуудсыг бөглөж хэвшсэн байна.</p> 
10.	<p>17.3 Музей нь утааны мэдрэгч, гал гарсан тохиолдолд ашиглах зориулалттай галын автомат гидрант, аврах шат, хаалга, тэдгээрийн байршлын тойм зураглал, яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбоо зэргээр бүрэн тоноглогдсон байна.</p>	<p>Үзүүллэгийн танхимд 10ш утаа мэдрэгчтэй. Яаралтай мэдээлэл дамжуулах цахилгаан холбооны 3ш зөөврийн станцтай. Гамшиг ослын үед ашиглах план зураг хэвлэн танхимд байрлуулсан.</p>  
11.	<p>17.4 Музейн ажилтан нь болзошгүй ослын үед ажиллах сургалтад хамрагдаж дадлагажсан, бэлэн байна.</p>	<p>Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд 2024 оны 87 дугаар албан бичиг илгээж Тус Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн байранд гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр музейн албан хаагчид 2024 оны 6 дугаар сарын 17 –нд сургалтад хамрагдсан. 2023 оны 3 дугаар сард шинэчлэн батлагдсан байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-д “Аврах, гал унтраах бүлэг”-ийг музейн захирлын 2023 оны 08 дугаар тушаалаар шинээр байгуулсан.</p> 
12.	<p>17.6 Барилга агааржуулалтын системтэй байна.</p>	<p>Үзүүллэгийн танхимд халуун хүйтнээр үлээдэг 3 ш агааржуулагчтай.</p>
13.	<p>17.7 Музейн барилга, байгууламж нь гал усны гэнэтийн аюул, хулгайн гэмт халдлагаас хамгаалах зориулалтын телекамер бүхий дохиоллын хэрэгсэлтэй байна. Дохиоллын хэрэгслийг байнга шалгаж байна.</p>	<p>Соёлын яам, Бодь Электроникс ХХК нарын хооронд СОЯ/202212021 тоот гэрээ байгуулагдаж, Улаанбаатар хотын музейд 2023 онд камер болон дохиолол хамгаалалтын системийг иж бүрэн суурилуулсан. Үзүүллэгийн танхимд камер 9ш, утаа мэдрэгч 10ш, шил хагаралтын мэдрэгч 10ш, хөдөлгөөн мэдрэгч 7ш, 30</p>

Захирлын дэргэдэх арга зүйн зөвлөлийн үзлэгийн мөрөөр
авсан арга хэмжээнд үзлэг шалгалт хийсэн тухай хүснэгт

Д/д	Захирлын дэргэдэх арга зүйн зөвлөлийн 2024 оны 2 дугаар үзлэгийн мөрөөр авсан арга хэмжээ	Тайлбар
1.	<p>СӨҮТ-д илгээсэн албан бичгийн дагуу дээрх хоёр үзмэрийг яаралтай цэвэрлүүлэх</p> 	<p>НСУГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/264 дүгээр албан бичгийг үндэслэн музейн захирлын 2024 оны А/26 дугаар тушаалаар “Л.И.Брежнев”, “Сувдан чимэгтэй зээгт наамал бурхан” гэсэн 2 дэсийн 2 ширхэг үзмэрийг тусгаарлах өрөөнөөс сан хөмрөгч П.Ариунаа, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал, арга зүйч Б.Өлзийбаяр нар зөөж тээвэрлэх журмын дагуу өмнөх болон дараах явцын зураг авч, бичлэг хийн баримтжуулан, боож баглан, “Үзмэр, эд зүйлийг түр гаргах, буцаах акт №ГБ-2024-02”-ийг үйлдэн хөдөлгөөнд оруулав.</p> <p>СӨҮТ-ийн хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга М.Оюунтулга, ерөнхий сэргээн засварлагч С.Даваадарь нарт хүлээлгэн өгсөн. Дээрх 2 үзмэрийг тусгай тавцанд байрлуулан үзмэрийн нүүр хэсгийг зориулалтын кальки цаасаар бүрж, тусгайлан бэлтгэсэн вакуумжуулах уутанд хийн, уутны завсраар нүүрстөрөгчийн азотын хоолойг оруулан, мөн хийг шалгах детектер төхөөрөмж байрлуулан, уутны амыг скочоор битүүмжилсэн. Ингээд хийн баллоноос хоолойгоор уут руу детектер төхөөрөмжийн заалтыг 5000 хүртэл хийг шахан дүүргэсэн. 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдөр 2 үзмэрээ буцаан хүлээн авсан.</p> <p>Зөөж тээвэрлэх үйл ажиллагаа хэвийн явагдсан бөгөөд музейд авчиран, 2 үзмэрээ жаазлан музейн 1 дүгээр танхимдаа байрлуулсан.</p>
2.	<p>СӨҮТ-өөс мэргэжилтэн урьж үзмэрт үзлэг шалгалт хийх</p>	<p>2024 оны 07 дугаар сарын 3 СӨҮТ-ийн хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газрын дарга М.Оюунтулга ирж дараах зүйлийг зөвлөлөө. 2 үзмэрийг үзэж үзүүлэгийн танхимаас гарган, 2 үзмэрээ битүүмжлэн өөр өрөөнд хадгалах хэрэгтэй, Л.И.Брежнев – хатгамал нь даавуун суурьтай, торгон утсаар оёсон, Сувдан чимэгтэй бурхан нь зээгт наамал үзмэр тул хөлдөөж болохгүй. Нүүрстөрөгчийн давхар ислээр утаж үзмэрийг цэвэрлэх хэрэгтэй. Ийм төхөөрөмж СӨҮТ-д нэг байдаг боловч маш их ачаалалтай байдаг. Тиймээс эхлээд СӨҮТ-д албан бичгээр хүсэлт гаргахыг зөвлөсөн.</p>
3.	<p>Дээрх тусгаарласан 2 үзмэр байсан ханын тоосыг цэвэрлэн сан хөмрөгөөс тухайн хэсгийн</p>	<p>2024 оны 07 дугаар сарын 3нд дээрх тусгаарласан 2 үзмэр байсан ханын тоосыг үзмэр харгалзагч Б.Ариунцэцэг цэвэрлэн UBM</p>

	дэглэлтэд нийцэх үзмэр гарган байрлуулах	84.36 хувийн дугаартай Энх тайвны гудамж – уран зураг сан хөмрөгөөс гарган, хэвлэмэл самбарын хамт байрлуулсан.
4.	UBM74.23 хувийн дугаартай Нийслэл хүрээ - уран зургийг даавуун бүтээлэг хуучирч, тоос дарж бохирдсон тул шинээр солих	2024 оны 7 дугаар сарын 4нд музейн үзүүлэгийн танхимд байгаа UBM74.23 хувийн дугаартай Нийслэл хүрээ уран зургийн үзмэрийн хамгаалалтын уут хуучирч, хиртэж муудсан, уяа бүч тасарсан байсныг шинэ ямбуу даавуугаар сан хөмрөгч П.Ариунаа оёж эрдэм шинжилгээний ажилтан, үзмэр харгалзагч нартай хамтран сольсон. 
5.	Үзүүлэгийн танхимын хана, шалны цэвэрлэгээ муу, тоос шороо ихтэй байгаа тул их цэвэрлэгээ хийх	Үзмэр харгалзагч Б.Ариунцэцэг, Б.Адъяа нар үзүүлэгийн танхимын хана, шал, замтай гэрлийн тоос шороог арчиж их цэвэрлэгээ хийв. 2024 оны 7 сарын 5
6.	Үзмэрийн хаяг тайлбаруудын тоосыг сайтар цэвэрлэх	Үзмэр харгалзагч Б.Ариунцэцэг үзмэрийн хаяг тайлбаруудын тоосыг цэвэрлэснийг Арга зүйч шалган “Цэвэрлэгээний хяналт шалгалтын хүснэгт”- д тэмдэглэгээ хийв.
7.	Үзмэрт тогтмол хяналт тавих	Арга зүйч Б.Өлзийбаяр, сан хөмрөгч П.Ариунаа нар үзмэрт тогтмол хяналт тавьж үзмэр харгалзагч П.Ариунцэцэгт зааварчилгаа өгч ажиллаж байна.

ДҮГНЭСЭН: Б.ӨЛЗИЙБАЯР
(Арга зүйч)

..... Б.НАРАНГЭРЭЛ
(Менежер)

..... Ч.ӨСӨХЖАРГАЛ
(Бүртгэл мэдээллийн санч)

..... О.ОДСҮРЭН
(Эрдэм шинжилгээний ажилтан)